



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 89

Сангийндалай

Нийтийн халуун усны үйлчилгээний
хураамжийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, 59 дүгээр зүйлийн 59.1.6 хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ :

1. “Нийтийн халуун усны үйлчилгээний хураамж”-ийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. “Нийтийн халуун усны үйлчилгээний хураамж”-ыг шинэчлэн батлагдсан өдрөөс эхлэн мөрдүүлж, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажиллахыг Засаг дарга (Б.Лхагвамандал)-д үүрэг болгосугай.

3. Үйлчилгээний хураамж шинэчлэн тогтоосонтой холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 07 сарын 28-ны өдрийн 2 дугаар хавсралтыг хүчингүй болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Өмч хамгаалах зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Н.ЧУЛУУН

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



Нийтийн халуун усны үйлчилгээний
хураамж

Д/д	Үйлчилгээний төрөл	Хураамж / төгрөг/
1	Том хүн	3000
2	Хүүхэд /8-15 нас /	1000
3	Сауна /1 цаг /	10000
4	Хувцас угаалгын түрээс	30000